



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Аудитор: Б.Батчимэг
---	---

1. Хараат бус аудиторын дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайнсанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.26 № 1-6/146

танай _____ -ны № _____ -т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.УРАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэрэх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн өөрчлөлтийг төсвийн шууд захирагчийн шийдвэргүйгээр ХНУМТ цахим системээс мэдээллийг шинэчлэн тооцоолсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сургуулийн захирлын А/26, Б/46 дугаар тушаалаар цалингийн зардлаас 3.8 сая төгрөгийг нэг удаагийн шинжтэй урамшуулалд, мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас 0.9 сая төгрөгийг интернетийн төлбөрт зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад асуудал

Сургуулийн захирлын 2024 оны Б/45 дугаар тушаалаар сургуулийн менежерийн салбарын шагналын дагалдах урамшуулалд 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

442502014

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,905,762.62	314,366,882.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,391,563.79	215,628,983.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	85,391,563.79	215,628,983.45
3121	Төгрөг	85,391,563.79	215,628,983.45
31211	Төрийн сангийн харилцах	85,391,563.79	215,628,983.45
33	АВЛАГА	3,146,774.28	425,982.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,755,174.28	34,382.76
335	Бусад авлага	391,600.00	391,600.00
3351	Байгууллагаас авах авлага	391,600.00	391,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,367,424.55	98,311,916.55
351	Түүхий эд материал	1,694,000.00	2,338,200.00
35130	Эм боох материал	1,694,000.00	2,338,200.00
354	Хангамжийн материал	73,703,424.55	92,003,716.55
35410	Бичиг хэргийн материал	22,645,177.47	18,424,187.47
35420	Аж ахуйн материал	41,618,919.08	60,874,903.08
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,159,400.00
35460	Хүнсний материал	4,910,378.00	8,025,076.00
35470	Бусад хангамжийн материал	4,528,950.00	3,520,150.00
35600	Мал амьтад	3,970,000.00	3,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	628,889,207.64	578,732,108.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	628,889,207.64	578,732,108.36
392	Биет хөрөнгө	596,647,332.32	546,706,108.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,564,301.00	599,564,301.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(186,470,079.80)	(232,051,962.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,528,760.00	37,130,760.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,528,760.00)	(17,528,760.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	252,103,253.11	243,992,647.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,735,677.10)	(144,652,598.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,071,983.82	106,870,318.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(80,306,381.23)	(86,280,745.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,689,977.30	61,189,977.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,788,264.58)	(46,559,268.76)
39217	Ном	25,518,219.80	25,031,438.74
393	Биет бус хөрөнгө	32,241,875.32	32,026,000.00
39301	Программ хангамж	5,492,400.00	5,492,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,276,524.68)	(5,492,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,026,000.00	32,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	796,794,970.26	893,098,991.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,827,171.00	2,974,906.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,827,171.00	2,974,906.00
413	Өглөг	1,827,171.00	2,974,906.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	454,772.00	2,999.00
4136	Бусад өглөг	1,372,399.00	2,971,907.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,291,340.00	2,890,848.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	81,059.00	81,059.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	794,967,799.26	890,124,085.12
51	Засгийн газрын хувь оролцоо	794,967,799.26	890,124,085.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	372,549,179.90	372,549,179.90
51101	Өмч: - төрийн	372,549,179.90	372,549,179.90
512	Хуримтлагдсан үр дүн	111,935,457.23	207,091,743.09
51210	Өмнөх үеийн үр дүн	111,935,457.23	111,935,457.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	95,156,285.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	310,483,162.13	310,483,162.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	796,794,970.26	893,098,991.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	805,726,753.72	1,293,855,634.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,555,800.00	54,899,296.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,555,800.00	54,899,296.90
120009	Бусад орлого	1,555,800.00	11,822,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		36,183,896.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		6,892,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	804,170,953.72	1,238,956,337.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	711,657,300.00	1,141,087,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,657,300.00	1,141,087,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,363,005.72	97,869,337.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,363,005.72	97,869,337.21
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	866,360,709.15	1,194,700,796.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	866,360,709.15	1,194,700,796.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,360,709.15	1,194,700,796.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,925,271.03	772,489,767.55
210101	Үндсэн цалин	373,186,777.03	543,744,228.09
210102	Нэмэгдэл	138,705,692.00	208,332,025.66
210104	Урамшуулал	11,032,802.00	20,413,513.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,871,184.18	95,646,511.00
210201	Тэтгэврийн даатгал	47,234,017.00	66,197,738.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,530,019.18	8,317,266.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069,986.00	3,915,237.00
210204	Ажилгүйдлийн даатгал	700,300.00	3,379,258.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,336,862.00	13,837,012.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,363,005.72	94,834,597.21
210301	Гэрэл, цахилгаан	5,159,121.72	5,962,605.21
210302	Түлш, халаалт	83,213,936.00	86,444,578.00
210303	Цэвэр, бохир ус	1,989,948.00	2,427,414.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,006,940.00	24,047,916.91
210401	Бичиг хэрэг	3,809,550.00	9,951,540.00
210402	Тээвэр, шатахуун	245,100.00	3,036,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,435,516.91
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,952,290.00	9,624,340.00
2105	Норматив зардал	68,177,678.00	66,576,532.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,690.00	156,300.00
210502	Хоол, хүнс	67,817,988.00	66,420,232.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	390,000.00
210604	Урсгал засвар	-	390,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	865,900.00
210702	Дотоод албан томилолт	-	865,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,070,300.00	24,601,653.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,555,300.00	19,415,340.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,515,000.00	4,322,312.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,946,330.22	115,247,918.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,494,900.00	9,315,474.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,451,430.22	103,892,444.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(60,633,955.43)	99,154,838.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,998,552.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,198,300.96

225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		800,251.21
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,998,552.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(60,633,955.43)	95,156,285.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>805,726,753.72</u>	<u>1,250,779,137.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,555,800.00	11,822,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,555,800.00	11,822,800.00
120009	Бусад орлого	1,555,800.00	11,822,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	804,170,953.72	1,238,956,337.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	711,657,300.00	1,141,087,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,657,300.00	1,141,087,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,363,005.72	97,869,337.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,363,005.72	97,869,337.21
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>773,603,858.93</u>	<u>1,098,991,717.55</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,603,858.93	1,098,991,717.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,834,858.93	1,066,508,217.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,925,271.03	770,208,749.03
210101	Үндсэн цалин	373,186,777.03	541,463,209.57
210102	Нэмэгдэл	138,705,692.00	208,332,025.66
210104	Урамшуулал	11,032,802.00	20,413,513.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,416,412.18	95,646,511.00
210201	Тэтгэврийн даатгал	46,779,245.00	71,184,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,530,019.18	6,115,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069,986.00	3,057,694.00
210204	Ажилгүйдлийн даатгал	700,300.00	3,057,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,336,862.00	12,230,778.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,363,005.72	94,834,597.21
210301	Гэрэл, цахилгаан	5,159,121.72	5,673,723.21
210302	Түлш, халаалт	83,213,936.00	86,354,290.00
210303	Цэвэр, бохир ус	1,989,948.00	2,806,584.00
2105	Норматив зардал	37,303,420.00	37,051,430.00
210502	Хоол, хүнс	37,303,420.00	37,051,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,999,740.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,999,740.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,070,300.00	23,650,403.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,555,300.00	1,591,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,515,000.00	22,058,703.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,756,450.00	42,116,786.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,421,450.00	35,766,886.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,335,000.00	6,349,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,769,000.00	32,483,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,769,000.00	32,483,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,769,000.00	32,483,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>32,122,894.79</u>	<u>151,787,419.66</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,545,800.00	21,550,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,545,800.00	21,550,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,545,800.00	21,550,000.00

222001	Тоног төхөөрөмж	21,545,800.00	20,830,000.00
223001	Бусад хөрөнгө	-	720,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,545,800.00)	(21,550,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,577,094.79	130,237,419.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		85,391,563.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,391,563.79	215,628,983.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	111,935,457.23	794,967,799.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	111,935,457.23	794,967,799.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	111,935,457.23	794,967,799.26
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	111,935,457.23	794,967,799.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	111,935,457.23	794,967,799.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	95,156,285.86	95,156,285.86
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	372,549,179.90	310,483,162.13	207,091,743.09	890,124,085.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,335,213,800.00	1,120,541,717.55	214,672,082.45	83.92%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,335,213,800.00	1,120,541,717.55	214,672,082.45	83.92%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,297,064,200.00	1,088,058,217.55	209,005,982.45	83.89%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	924,610,300.00	770,208,749.03	154,401,550.97	83.30%
210101	Үндсэн цалин	594,857,800.00	541,463,209.57	53,394,590.43	91.02%
210102	Нэмэгдэл	326,603,000.00	208,332,025.66	118,270,974.34	63.79%
210104	Урамшуулал	3,149,500.00	20,413,513.80	(17,264,013.80)	648.15%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,576,100.00	95,646,511.00	19,929,589.00	82.76%
210201	Тэтгэврийн даатгал	78,591,800.00	71,184,739.00	7,407,061.00	90.58%
210202	Тэтгэмжийн даатгал	9,246,100.00	6,115,600.00	3,130,500.00	66.14%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,623,000.00	3,057,694.00	1,565,306.00	66.14%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,623,000.00	3,057,700.00	1,565,300.00	66.14%
210205	Эрүүл мэндийн даатгал	18,492,200.00	12,230,778.00	6,261,422.00	66.14%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,886,600.00	94,834,597.21	8,052,002.79	92.17%
210301	Гэрэл, цахилгаан	9,156,000.00	5,673,723.21	3,482,276.79	61.97%
210302	Түлш, халаалт	86,830,600.00	86,354,290.00	476,310.00	99.45%
210303	Цэвэр, бохир ус	6,900,000.00	2,806,584.00	4,093,416.00	40.68%
2105	Норматив зардал	55,433,800.00	37,051,430.00	18,382,370.00	66.84%
210502	Хоол, хүнс	55,433,800.00	37,051,430.00	18,382,370.00	66.84%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,999,740.00	260.00	99.99%
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,999,740.00	260.00	99.99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,750,200.00	23,668,403.40	81,796.60	99.66%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,673,400.00	1,591,700.00	81,700.00	95.12%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,076,800.00	22,076,703.40	96.60	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,807,200.00	63,648,786.91	8,158,413.09	88.64%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,798,100.00	55,648,886.91	8,149,213.09	87.23%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,009,100.00	7,999,900.00	9,200.00	99.89%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,149,600.00	32,483,500.00	5,666,100.00	85.15%
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,149,600.00	32,483,500.00	5,666,100.00	85.15%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,149,600.00	32,483,500.00	5,666,100.00	85.15%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,335,213,800.00	1,250,779,137.21	84,434,662.79	93.68%
120	Нийтлэг татварын бус орлого	11,822,800.00	11,822,800.00	-	100.00%
120009	Бусад орлого	11,822,800.00	11,822,800.00	-	100.00%

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,141,087,000.00	1,141,087,000.00	-	100.00%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,141,087,000.00	1,141,087,000.00	-	100.00%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,886,600.00	97,869,337.21	8,017,262.79	92.43%
132001	Орон нутгийн төсвөөс	105,886,600.00	97,869,337.21	8,017,262.79	92.43%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	76,417,400.00	-	76,417,400.00	0.00%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	76,417,400.00	-	76,417,400.00	0.00%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		85,391,563.79	(85,391,563.79)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		215,628,983.45	(215,628,983.45)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33.00	33.00	-	100.00%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-	100.00%

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 108.3 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 103.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 4.8 сая төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлэв.

3.1. Аудитын явцад залруулсан алдаа:

1. Орлого, үр дүнгийн тайланд зардлын ангиллыг нийт 101.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

2. Сумын ИТХ-ын шийдвэрээр акталсан болон хөрөнгийн үнийг дахин шинэчлэн тогтоосон хөрөнгийн зарлагыг гүйцэтгэхдээ буруу зардлын данс сонгож, нийт 26 хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлд 1.9 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.

3.2. Төлбөрийн акт:

Аудитаар тогтоосон төлбөрийн акт байхгүй болно.

3.3. Албан шаардлага:

Аудитаар өгсөн албан шаардлага байхгүй болно.

3.4. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд сургуулийн захирлын А/26, Б/46 дугаар тушаалаар цалингийн зардлаас 3.8 сая төгрөгийг нэг удаагийн шинжтэй урамшилд, мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас 0.9 сая төгрөгийг интернетийн төлбөрт зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нэг удаагийн шинж чанартай урамшууллыг цалингийн зардлаас олгохгүй байх

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой:

2.1. **Илрүүлэлт:** Байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн өөрчлөлтийг төсвийн шууд захирагчийн шийдвэргүйгээр ХНУМТ (хүний нөөцийн удирдлагын мэдээллийн төв) цахим системээс мэдээллийг шинэчлэн тооцоолсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “*батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 5-т “*Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн*

байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд өөрчлөлт орох бүрт төсөв захирагчийн шийдвэрт үндэслэн олгох

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой:

- 3.1. **Илрүүлэлт:** Тайлант оны ерөнхий журналд 148.6 сая төгрөгийн нийгмийн даатгал, ХХОАТ болон үйлдвэрчний эвлэлийн өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3 дугаар бүлгийн 3.5-т заасан “*Ажилтны цалин хөлс, олговрыг дараах байдлаар бүртгэнэ*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3 дугаар бүлгийн 3.5 дахь хэсгийн дагуу цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгах

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой:

- 4.1. **Илрүүлэлт:** Тайлан онд мэдээлэл оруулах хэрэглэгчийн эрхийг тохируулаагүйн улмаас 5 сая төгрөгөөс дээш 10.0 сая төгрөгийн 1 орлогын, 126.8 сая төгрөгийн 14 зарлагын гүйлгээг огт байршуулаагүй байна. Мөн “үдийн цайны хөтөлбөр” болон “дотуур байрны хүнсний материал худалдан авах” худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон тайлан, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 4.1.3-т “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.8-т “*..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ*”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “*цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт*”, 8.4.8-т “*..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
